

III. БАЯНХОНГОР АЙМГИЙН АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

А.Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан хэдий ч Засгийн газрын 1998 оны 149-р тогтоолоор батлагдсан журмын 8 “орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална” гэсэн заалтыг зөрчин аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар баталгаажуулсан байна.

А.1 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.

Авто замын тухай хуулийн 6.1.1-т “авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан тухайн орон нутгийн авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчилж хамгаалах бодлого боловсруулж төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах,” гэсэн заалтын дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 4-р сарын 4-ны өдрийн хуралдаанаар Баянхонгор аймагт 2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, зарцуулах төсвийн хэмжээг хэлэлцэж, шинээр гүйцэтгэх 16 ажилд 320,0 сая төгрөг, өмнөх онд хэрэгжсэн боловч санхүүжилт дутуу олгогдсон 5 ажилд 21,5 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэж, ИТХТ-ийн 25-р тогтоолоор баталгаажуулжээ. Тайлант жилийн хугацаанд дээрх тогтоолд 4 удаа өөрчлөлт оруулжээ. Тухайлбал: ИТХТ-ийн 2016.05.20-ны 43-р тогтоолоор шинээр хэрэгжүүлэх 7 төсөл арга хэмжээг нэмэгдүүлж, 178,4 сая төгрөг, 2016.06.10-ны 47-р тогтоолоор 4-р сард 25-р тогтоолоор батлагдсан зарим арга хэмжээнд 15,0 сая төгрөг /Зорчигч тээврийн авто зогсоолд-1,0 сая, ХААН банк, ҮЭ-ийн өмнөх талбайд нийлээд 10,0 сая төгрөг байсныг ҮЭ-ийн өмнөх талбайг салгаж-9,0 сая төг, Анар худалдааны төвийн өмнөх талбайд 5,0 сая.төг/, 2016.09.28-ны 89-р тогтоолоор 2,3,7,9-р багийн үерийн усанд эвдэгдсэн зам талбайг засварлах ажилд 26,9 сая төгрөг баталж, Цагаан хөтлийн цагдаагийн постын гэрлийн төлбөрт 1,0 сая төгрөг нэмэгдүүлсэн, 2016.10.09-ны 97-р тогтоолоор Албан журмын даатгалын холбоонд 2,5 сая төгрөг, Хандивын цэцэрлэгийн өмнөх автомашины зогсоолын зардалд 4,0 сая төгрөг, Цагаан хөтлийн цагдаагийн постын цахилгааны зардалд 5,0 сая төгрөг,

тус тус нэмэгдүүлж, 2016.05.20-ны 43-р тогтоолоор батлагдсан явган хүний замын засварын 20,0 сая төгрөгийн төсвийг хассан шийдвэр гаргажээ.

А.2 Замын сангийн хөрөнгийг шаардлагагүй, үр ашиггүй төсөл арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн санал, дүгнэлт болон Хөгжлийн бодлогын хэлтсийн холбогдох албан тушаалтнууд, иргэд олон нийтээс ирүүлсэн саналд үндэслэж, тайлант онд хэрэгжүүлэх авто зам, гүүрийн байгууламжид засвар, арчлалт, өргөтгөл, шинэчлэлт хийх талаарх 2016 оны ажлын жагсаалтыг гаргаж, төлөвлөгөөг батлуулсан байна.

А.3 2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн ажилд газрын зөвшөөрөл техникийн нөхцөл шаардлагагүй байна.

Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл шаардлагагүй зам талбай, зогсоолд шинээр зам тавих, зогсоол байгуулах, засвар шинэчлэлийн ажлууд хийсэн байна.

А.4 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг мэргэжлийн байгууллага, хүмүүсээр хийлгээгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг Сангийн сайд, дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/61 тоот тушаалаар батлагдсан журмын 3.3 “Хайгуул, зураг, төсөл, төсвийг **мэргэжлийн байгууллага, хүмүүс тооцож**, аймаг хотын засаг даргаар баталгаажуулна” гэсэн заалтын дагуу аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн А.Дорж гүйцэтгэж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн, мэргэжлийн төсөвчин Д.Магвансүрэн хянан баталгаажуулсан байна. Замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөрийн захиалагч нь аймгийн ЗДТГазар байхад төсвийг мэргэжлийн байгууллага, хүмүүсээр хийлгүүлээгүй, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн А.Дорж гүйцэтгэж, мэргэжлийн төсөвчин Д.Магвансүрэн хянан баталгаажуулсан байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1.”Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалттай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл өөрийн хийсэн төсөвт ажлыг өөрөө хянаж байгаа нь зөрчил үүсгэж байна. Гүйцэтгэгч компаниуд дээрх зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэжээ.

А.5 Замын сангийн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүй нэмсэн, санхүүжих дүнд өөрчлөлт оруулсан асуудал байхгүй байна.

Аймгийн ИТХТ-ын 2016 оны 4-р сарын 4-ны 25-р тогтоолоор батлагдсан замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалтад орсон ХААН банк, ҮЭ-ийн өмнөх талбайн төсвийг 10,0 сая төгрөгөөр баталсан боловч, аймгийн ИТХТ-ийн 2016 оны 6-р сарын 10-ны 47-р тогтоолоор ҮЭ-ийн өмнөх талбайг салгаж, 9,0 сая төгрөгөөр, хандиваар баригдсан цэцэрлэгийн гаднах талбайн төсвийг 4,0 сая төгрөгөөр тус тус нэмж баталсан байна.

Төсөвт зардлын тооцоо хийгдээгүй байхад ХААН банк, ҮЭ-ийн өмнөх талбайн ажлыг ИТХТ-ийн хурлаар жагсаалтад оруулснаас төсвийг шинээр хийж ҮЭ-ийн өмнөх талбайн зардлыг нэмэгдүүлжээ. Хандивын цэцэрлэгийн гаднах талбай нь байгалийн төрхөөрөө байсан газар дээр хийгдэх ажил учраас төсөв өртгийг нь 4,0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

А.6 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээний нэр, эхлэх дуусах хугацаа, байршлыг өөрчлөөгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр батлагдсан ажлын жагсаалтын эхлэх, дуусах хугацаа, байршлыг өөрчлөөгүй байна.

А.7 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажилд тавих шат шатны хяналтын үүргийг журмын дагуу гүйцэтгэжээ.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажилд тавих шат шатны хяналтын үүргийг Сангийн сайд, дэд бүтцийн сайдын 2000 оны 47/61 тушаалаар батлагдсан журмын 4.5 дахь заалтын дагуу захиалагч талын төлөөлөл, аймгийн ЗДТГ-ын болон сумын ЗДТГ-ын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, МХГ-ын авто зам, тээвэр хариуцсан улсын байцаагч болон холбогдох эзэмшигч байгууллагын удирдлагууд тухай бүр нь гүйцэтгэж иржээ.

Б.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу үр нөлөөтэй зохион байгуулсан байна.

Б.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, ил тод, шуурхай байдлыг хангасан эсэх

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын үнэлгээний хороог журмын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар төсөл, хөтөлбөр, ажил бүр дээр гаргаж, нээлттэй, ил тод, шуурхай байдлыг ханган ажиллажээ. Тендерийн урилгыг тухайн үед ашиглаж байсан Засгийн газрын худалдан авах ажиллагааны нэгдсэн сайт www.e-procurement.mof.gov.mn –д тухай бүр нь нийтэлсэн байна.

Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тухайн ажлыг гүйцэтгэх зориулалтын тоног төхөөрөмж дутагдалтай зарим компанийг шалгаруулж байжээ.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх 10 ажлын сонгон шалгаруулалтыг явуулахдаа 2 ажлын тендерийг цаасаар, 8 ажлыг цахимаар авч харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хуулийн дагуу зохион байгуулагдсан хэдий ч Элбата ХХК нь тоног төхөөрөмжийн дутагдалтай байснаас гэрээгээ цуцлуулсан байна. Тухайн ажлыг Их Богд зам ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Б.3 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын 80 орчим хувь нь гэрээнд заасан хугацаандаа бүрэн гүйцэтгэгдсэн байна.

Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн хатуу хучилттай болон хөрсөн замд үерийн улмаас үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажлаас бусад замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын тендер хүлээх авах, шалгаруулах, гүйцэтгэх бүх шатны ажлууд гэрээнд заасан цаг хугацаандаа бүрэн хийгдсэн байна.

Б.4 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын худалдан авах ажиллагаанаас бий болсон хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зүйлд зарцуулаагүй байна.

Замын санд батлагдсан төсвийн тендерийн хэмнэлтийг зориулалт бус зарцуулаагүй байна.

Б.5 Авто замын тэмдэг, тэмдэглэгээ хийх ажилд шаардлага хангаагүй компани шалгаруулснаас шалтгаалж ажлын гүйцэтгэл хойшлогдсон байна.

Тэмдэг, тэмдэглэгээ хийх зориулалтын тоног төхөөрөмжгүй Элбата ХХК-ийг аймгийн төвийн авто замын зорчих хэсэгт хэвтээ тэмдэглэгээ хийх тендерт шалгаруулснаас уг ажлын гүйцэтгэл хойшлогдож, Их Богд зам ХХК-иар гүйцэтгүүлсэн байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын тендерт шалгарсан бусад компаниуд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсэн байна.

Б.6 Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөж, батлагдсан төсөл арга, хэмжээнээс 20,0 сая төгрөгийн өртөгтэй явган замын засварын ажлыг ИТХТ-ийн 2016 оны 10-р сарын 9-ний 97-р тогтоолоор хассан шийдвэрээс өөр өөрчлөлт ороогүй байна.

В. Баянхонгор сумын 2,3,7,9-р багийн хатуу хучилттай болон хөрсөн замд үерийн улмаас үүссэн эвдрэл гэмтлийг засварлах ажил /Хөх толгойн шороон хөрсөн болон Арван мянгатын голын, төв захын арын асфальтан замын засвар/ дуусаагүй, харин бусад замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт нь үр нөлөөгөө өгсөн байна.

В.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхой, оновчтой, гэрээний хугацаа бүрэн заагдсан байна.

1. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн гаднах 1250м² автомашины зогсоолын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4-р сарын 25-ны 262-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар тендер шалгаруулах журмаар цахимаар зарлаж, Наран тээг компани ХХК шалгарсан байна. Тус компани дээрх ажлыг 2016 оны 5 дугаар сарын 26-аас 6 дугаар сарын 15-ны хугацаанд 13,4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж, 2016 оны 6-р сарын 07-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



2. Хотын төвийн авто замын гэрэлтүүлгийг 100вт-ын LED гэрэлтүүлгээр солих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 5-р сарын 23-ны 326-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар тендер шалгаруулах журмаар цахимаар зарлахад нэг ч компани саналаа ирүүлээгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33-р зүйлийн 33.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулан тухайн ажлыг гүйцэтгүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Ингээд Баянхонгор сумын “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-аар 2016 оны 6-р сарын 3-аас 6-р сарын 29-ны хооронд 17,2 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулжээ. Гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгэж, 2016 оны 7-р сарын 6-ны өдөр ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна.



3. Аймгийн төвийн авто замын зорчих хэсэгт хэвтээ тэмдэглэгээ 500м², 25 ширхэг тэмдгийг 14.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4-р сарын 25-ны 259-р захирамжаар байгуулсан байна. Дээрх ажлын тендерт 4 компани материал ирүүлснээс Элбата ХХК-ийг шалгаруулжээ. Элбата ХХК нь уг ажлыг 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 22-ны хооронд гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Гэвч тус компани нь замын тэмдэг, тэмдэглээ хийх зориулалтын тоног төхөөрөмжгүйгээс гэрээг цуцалж, 2016 оны 7-р сарын 4-ний өдөр “Их богд зам” ХХК компанитай дахин гэрээ байгуулжээ. Их Богд зам компани нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, ажлаа хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна.



4. Эрдэнэмандал ахлах сургуулийн гаднах автомашины зогсоолын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4-р сарын 25-ны 257-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар тендер шалгаруулах журмаар цахимаар зарлаж, Эс Эм Жи, Елбата гэсэн 2 компани материал ирүүлснээс Эс Эм Жи ХХК 19,9 сая төгрөгийн үнийн санал ирүүлж шалгарсан байна. Тус компани нь Эрдэнэ мандал ахлах сургуулийн гаднах 800м² авто зогсоолын ажлыг 2016оны 5-р сарын 23-аас 6-р сарын 14-ний хооронд гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, 2016 оны 8-р сарын 9-нд техникийн комисс-т хүлээлгэн өгсөн байна.



5. Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын засвар арчлалтаар 2016 онд 1270м^2 талбайд нөхөөс, 2 автобусны зогсоолын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендерт материал ирүүлээгүй тул “Их богд зам” ХХК-тай шууд гэрээ байгуулжээ. Тус компани нь дээрх ажлыг 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 27-ны хооронд, 68.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.



6. Баянхонгор сумын 19,25 дугаар байрны гаднах 1520м^2 авто машины зогсоол болон авто замын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 4- сарын 25-ны 260-р захирамжаар байгуулж, тендерийг харьцуулалтын аргаар, цахим хэлбэрээр шалгаруулахаар зарласан байна. Их Богд зам ХХК, Элбата ХХК гэсэн 2 компани уг ажлыг гүйцэтгэх тендерийн материал ирүүлснээс Элбата ХХК-ийг шалгаруулсан байна. Тус компани нь дээрх ажлыг 2016 оны 5-р сарын 25-аас 6-р сарын 17-ны хооронд 33,0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Тендерт заагдсан ажлыг бүрэн гүйцэтгэж, 2016 оны 6-р сарын 7-ны өдөр хүлээлгэн өгсөн байна.



7. 2,7 дугаар багийн нутаг дэвсгэр дэхь сайжруулсан хөрсөн замын 100000м² талбайд хүсэлт хийх, 720м³ хуучин шуудуу сэргээх ажлыг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ 2016 оны 6 дугаар сарын 5-наас 06 сарын 25-ны хооронд 7.4 сая төгрөгийн өртөгтэйгөөр шууд гэрээгээр гүйцэтгэжээ.



8. ХААН банкны гаднах 750м² авто зогсоолыг “Наран тээг” ХХК 10.0 сая төгрөгөөр 2016 оны 06 дугаар сарын 25-наас 2015 оны 09 дүгээр сарын 20-нд шууд гэрээгээр гүйцэтгэсэн.



9. Үйлдвэрчний эвлэлийн гаднах 650м² талбайг 9 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК шууд гэрээгээр 2016 оны 07 дугаар сарын 10-ны хугацаанд хийж гүйцэтгэсэн.



10. Анар дэлгүүрийн гаднах 170 м² зам талбайг 5 сая төгрөгөөр “Наран тээг” ХХК шууд гэрээгээр 2016 оны 07 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэсэн.



11. Номундалай сургуулийн өмнөх 150м авто замын тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 5-р сарын 23-ны 324 тоот захирамжаар байгуулж, цахимаар 40,0 сая төгрөгийн үнийн дүн бүхий тендер шалгаруулалт явуулж, “Галхонгор” ХХК компани 39,8 сая төгрөгийн үнийн саналтай материал ирүүлсэн байна. Өөр компани материал ирүүлээгүй тул “Галхонгор” ХХК-ийг шалгаруулжээ. Тус компани нь дээрх ажлыг зураг төсвийн дагуу, 2016 оны 07 дүгээр сарын 05-наас 07 дугаар сарын 20-ны хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, 2016 оны 8-р сарын 1-нд техникийн комисс-т хүлээлгэн өгсөн байна.



12. Төв захын арын замын өргөтгөл болон зах доторх авто машины зогсоол, бильярдны тоглоомын нийт 1850м² зам, талбайн ажлыг гүйцэтгүүлэх ажлын үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 5-р сарын 23-ны 328-р захирамжаар байгуулж, харьцуулалтын аргаар цахим тендер зарласан боловч нэг ч компани санал ирүүлээгүй байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33-р зүйлийн 33.4-т заасны дагуу шууд гэрээ байгуулан тухайн ажлыг гүйцэтгүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Иймээс 66,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй уг ажлыг 2016 оны 6-р сарын 17-оос 6-р сарын 30-ны хооронд “Их богд зам” ХХК-аар гүйцэтгүүлэх шууд гэрээ байгуулжээ. Тус компани дээрх ажлыг гүйцэтгэж, 2016 оны 07 дугаар сарын 9-нд техникийн комисс-т хүлээлгэн өгсөн байна.



13. Хандиваар баригдсан “Мазаалай” цэцэрлэгийн гаднах авто зогсоол болон замын 530м² талбайн ажлыг 9,9 сая төгрөгөөр гүйцэтгэх төсвийг аймгийн ИТХТ-ийн 2016 оны 5-р сарын 20-ны 43-р тогтоолоор баталсан бөгөөд “Нүнжигт инженерг” ХХК 2016 оны 06 дүгээр сарын 20-ноос 2016 оны 6 дүгээр сарын 24-ны хугацаанд гүйцэтгэх шууд гэрээ байгуулжээ. Дээрх төсвийг аймгийн ИТХТ-ийн 2016 оны 10-р сарын 9-ний 97-р тогтоолоор 4,0 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Уг ажлыг 2016 оны 8-р сарын 03-ны өдөр техникийн комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.



14. 13-р цэцэрлэг/төрийн банкны/-ийн гаднах талбайн авто зогсоолын ажлыг Алтайн гурван нуур ХХК-иар 2016 оны 6-р сарын 8-аас 6-р сарын 11-ний хооронд 9,7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

15. Баянхонгор сумын 1,2,3,7,9 дүгээр багийн нутаг дэвсгэр дэхь хатуу хучилттай болон хөрсөн замын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016 оны 10-р сарын 5-ны А/617-р захирамжаар байгуулсан байна. Тендерийг 2016 оны 10-р сарын 7-оос 10-р сарын 14-ний хооронд зарласан боловч 1 ч компани материал ирүүлээгүй байна. 26,9 сая төгрөгийн тендерийн сонгон шалгаруулалтаар “Их богд зам” ХХК 10 сард багтаан гүйцэтгэсэн.



В.2 Гэрээнд заасан ажлаа дутуу гүйцэтгэсэн Их Богд зам ХХК-аас бусад ажлын санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудаас 10,0 мянгатын голын замын засварын нөхөөс хийх ажил дуусаагүй тул санхүүжилтийг 5,6 сая төгрөгөөр дутуу олгосон. Бусад ажлыг бүрэн гүйцэтгүүлж, техникийн комисс хүлээн авсан тул санхүүжилтийг бүрэн олгожээ.

В.3 Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгосон, талуудын хяналт хангалтгүй, зураг төсөвт өөрчлөлт орсон, үргүй зардал гаргасан асуудал байхгүй.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудаас 10,0 мянгатын голын замын засварын ажлаас бусад ажил нь зураг төсвийн дагуу бүрэн хийгдсэн байна.

В.4 Төсөл арга хэмжээний санхүүжих дүн дутуу батлагдсанаас бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилсон асуудал байхгүй.

Аудитаар төсөл арга хэмжээний санхүүжих дүн дутуу батлагдсанаас бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилсон асуудал илрээгүй

В.5 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих талуудын хяналт хангалттай, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан байна.

Аудитаар замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажилд хяналт тавих эрх бүхий байгууллага болох МХГазар, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, худалдан авах ажиллагаатай холбоо бүхий аж ахуйн нэгж, байгууллагууд хяналтыг зохих журмын дагуу хийсэн байна.

В.6 Хэрэгжилт дууссан төсөл арга хэмжээг улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгосон асуудал илрээгүй.

Аудитаар дээрх зөрчил илрээгүй.

В.7 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр ашиг хангалттай, чанарын болон ашиглалтын шаардлага хангасан байна.

2016 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудаас 10,0 мянгатын голын зам, төв захын арын асфальтан замын засвараас бусад ажлууд бүрэн хийгдэж, гэрээний хэрэгжилт хангалттай, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр үр нөлөөтэй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулсан хэдий ч Засгийн газрын 1998 оны 149-р тогтоолоор батлагдсан журмын 8 “орон нутгийн замын сангийн хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймаг, нийслэлийн **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална**” гэсэн заалтыг зөрчин аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **Тэргүүлэгчдийн хурлаар** баталгаажуулсан байна. Энэ нь 2015 онд аймгийн Аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.

3. Засгийн газрын 2014 оны 184 дүгээр тогтоолын 1-т "Орон нутгийн зам, гүүрийг хариуцах байгууллагыг тодорхой болгон, сум, дүүргийн өмчид бүртгэн, бүртгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан" байхад 2016 онд Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлыг комисс хүлээн авсан боловч, хөрөнгөнд бүртгээгүй зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч 235.2 сая төгрөгийн хөрөнгийг орлого авахуулах албан шаардлагыг хүргүүлсэн байна. Тухайлбал: Замын сангийн хөрөнгөөр Гал хонгор ХХК-ийн гүйцэтгэсэн 1-р 10 жилийн урдуур шинээр тавьсан 39.8 сая төгрөгийн авто зам, Наран тээг ХХК, Эс жи эм ХХК, Елбата ХХК, Их богд зам ХХК, Нүнжигт инженеринг ХХК –ийн гүйцэтгэсэн 195.4 сая төгрөгийн албан газар, орон сууцны гаднах авто зогсоолуудын ажлыг хөрөнгөнд орлого аваагүй байна.

4. Авто замын зорчих хэсгийн замын тэмдэг, тэмдэглэгээ хийх ажлын тендерт 4 компани саналаа ирүүлснээс Элбата ХХК-ийг сонгон шалгаруулсан боловч тус компани нь замын тэмдэг, тэмдэглэгээ хий зориулалтын тоног төхөөрөмжгүй учир гэрээг цуцалж, Их Богд зам компаниар гүйцэтгүүлсэн нь тендерийн үнэлгээний хороо зарим шалгаруулалтыг хангалтгүй гүйцэтгэсэн байгааг харуулж байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА, ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ

1. Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, төсвийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн баталгаажуулж байх

2. Тендерийн үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тендерт оролцогчийн чадварын үнэлэх тухай 12 дугаар зүйл болон 14-16 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлж, тендер шалгаруулалт явуулахдаа тендерт материалаа ирүүлсэн компани нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зориулалтын тоног төхөөрөмжтэй эсэх, мэргэжлийн ажилчидтай эсэхийг нягталж, дүгнэлт гаргаж, шалгаруулж байх

3. ХААН банк, Үйлдвэрчний эвлэл, Анар дэлгүүрийн өмнөх болон 13-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг/хуучин төрийн банк/-ийн дэргэдэх автомашины зогсоол, талбайг тухайн албан газар, байгууллагуудад эзэмшүүлж, цаашдын засвар үйлчилгээний ажлыг хариуцуулах

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ